

“РАДИОГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА”-Д ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Үндэслэл, тайлбар

Монгол Улсын Их хурлаас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр соёрхон баталж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх “Зөвшөөрлийн тухай” хуульд нийцүүлэн “**Радиоогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага**”-д дараах өөрчлөлтийг оруулахаар санал авч байна.

“Зөвшөөрлийн тухай” хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хууль хүчингүй болох юм.

Иймд “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулиар зохицуулсан тусгай зөвшөөрөлтэй холбоотой эрх зүйн зохицуулалтуудыг “Зөвшөөрлийн тухай” хуульд нийцүүлэх шаардлагын үүднээс “Радиоогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д дараах өөрчлөлтийг оруулахаар санал авч байна.

“Радиоогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага” нь Зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 88 тоот тогтоолын хавсралтаар батлагдан, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болно.

№	Одоогийн заалт	Өөрчлөлт оруулах санал
1	1.2 Энэхүү нөхцөл, шаардлага нь Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль , холбогдох бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актад нийцсэн байна.	1.2 Энэхүү нөхцөл, шаардлага нь Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Зөвшөөрлийн хууль , холбогдох бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актад нийцсэн байна.
2	1.4 Төлбөртэй радиоогийн үйлчилгээнээс бусад радиоогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоход Зохицуулах хорооноос баталсан “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам”-ын дагуу нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмыг баримтлана.	1.4 Төлбөртэй радиоогийн үйлчилгээнээс бусад радиоогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоход Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5-д заасны дагуу нээлттэйгээр сонгон шалгаруулна.